ИХ ДЭЭД СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТЫГ СУДЛАХ НЬ

Б.Энхзул[1a], Б.Алтантүлхүүр[2b], Т.Алтангэрэл[3c]

[1] Мандах Их Сургууль, Гадаад Хэлний Тэнхим, Ph.D, багш
[2] Мандах Их Сургууль, Мэдээлэл Технологийн Сургууль, багш
[3] Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, багш
[a] enkhzul@mandakh.edu.mn
[b] altantulkhuur@mandakh.edu.mn
[c] altangerel@mnums.edu.mn

Өгүүлэл хүлээн авсан огноо: 20/05/2026
Өгүүлэл хэвлэсэн огноо: 01/07/2026
https://doi.org/10.67207/mrj.2026.15.14

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаа нь жендэрийн тэгш байдал хэмээх ойлголт их, дээд сургуулийн хэмжээнд хэр байгааг тодорхойлох мөн энэ ойлголтод нөлөөлж буй хүчин зүйлсийг шинжлэхэд оршино. Судалгаанд нийт 423 оролцогч хамрагдсаны 84.2% нь 18-25 насны оролцогчид байв. Энэ нь судалгааны дүнг их, дээд сургуулийн оюутнуудын хүйсийн тэгш байдлын талаарх ойлголт ямар байгааг дүгнэх боломжийг бүрдүүлж байна. Судалгааны асуулга нь гурван үндсэн хэсгээс бүрдэв. Үүнд: Ерөнхий мэдээллийн хэсэг – оролцогчийн нас, хүйс, суралцаж буй түвшин зэрэг демографик үзүүлэлтүүдийг агуулсан. Харин хүйсийн тэгш байдлын талаарх ойлголтыг тодруулах хэсэг нь эрэгтэй суралцагчдад чиглэсэн бодлого, дэмжлэгийн сул байдал, боловсролоос хөндийрөхөд нөлөөлөх гэр бүл, нийгэм, хувь хүний хүчин зүйлс болон жендэрийн үүрэг ба боловсролын үнэлэмжийн ялгаа гэсэн хүчин зүйлсээс бүрдэв. Судалгааны зорилгод нийцүүлэн судалгаанд оролцогчдын хариултад түүврийн хүрэлцээтэй байдал, хүчин зүйлс, найдвартай байдлын шинжилгээнүүдийг тус тус хийсэн. Уг шинжилгээний үр дүн нь регресс болон кластер зэрэг нарийвчилсан шинжилгээ хийх бүрэн боломжтойг илтгэсэн болно. Регрессийн шинжилгээний үр дүнд эрэгтэй суралцагчдад чиглэсэн бодлого, дэмжлэг сул байдал, олон нийтийн хэвшмэл ойлголтоос үүдэн дээд боловсролын хүрээнд жендэрийн тэгш бус байдал үүсдэг нь батлагдсан. Түүнчлэн кластер шинжилгээний үр дүнгээс жендэрийн тэгш байдал хэмээх ойлголтод оролцогчдын нас, боловсрол, хүйс зэрэг нөлөөлөх хүчин зүйлс статистик ач холбогдол бүхий хамааралтай нь ажиглагдав. Учир нь судалгаанд оролцогчдын нас, боловсрол зэргээс хамааран их, дээд сургуулийн хүрээнд жендэрийн тэгш байдлын талаар төвийг сахих үзэлтэй бүлгийг мэдээллээр хангах мөн жендэрийн тэгш байдлыг дэмжих хандлагатай бүлгийн тоог нэмэгдүүлэх бүрэн боломжтой байна.

Түлхүүр үгс: Тэгш байдал, жендэрийн ойлголт, дээд боловсрол, суралцагчдад чиглэсэн бодлого, боловсролоос хөндийрөх нь, үнэлэмжийн ялгаа

Удиртгал

Их, дээд боловсролын салбар дахь жендэрийн тэгш байдал нь боловсролын чанар, хүртээмж, тэгш оролцоог хангах тогтолцооны үндсэн хүчин зүйл хэмээн олон улсын судлаачид онцолдог. Албан ёсны түвшинд жендэрийн тэгш байдлыг бодлого, хөтөлбөрүүдээр дэмжиж байгаа боловч хэрэгжилтийн явцад байгууллагын соёл, нийгмийн хэвшмэл ойлголт, хүйсийн ялгаатай байдал зэргээс үүдэн тэгш бус байдал хадгалагдсаар байна (Unterhalter, E., 2017); (HutchinsonLori & editorStromquist, 2017). Монгол Улсын хувьд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль” батлагдсан хэдий ч, их, дээд боловсролын түвшинд бодитой дүн шинжилгээ, судалгаа харьцангуй хомс байна (ЭрдэнэчимэгБ., 2020).

Их, дээд сургуулиуд дахь жендэрийн тэгш байдлын талаарх оюутнуудын хандлага, ойлголт нь боловсролын орчинд жендэрийн оролцоо, боломжийн ялгааг тодорхойлох чухал үзүүлэлт юм. Тиймээс олон улсын судалгаануудад хүйсийн үүргийн хуваарилалт, боловсролын үнэ цэн, жендэрийн хэвшмэл ойлголт зэрэг нь оюутнуудад нөлөөлж байгааг тэмдэглэж байна (Bhana, 2009); (Skelton, 2012). Түүнчлэн Монголын их, дээд сургуулиудад жендэрийн мэдрэмжтэй сургалтын орчин, багшийн заах-арга зүй, сэтгэлзүйн дэмжлэгийг нэмэгдүүлснээр оюутнуудын ойлголт, оролцоог идэвхжүүлж буйг илтгэх судалгаа хомс байна.

Үүний зэрэгцээ боловсролын үнэ цэн, боловсролын талаарх хүйсийн ялгаатай хандлагад нийгмийн хүчин зүйлсийн нөлөөлөл илт ажиглагдаж байгаа нь жендэрийн тэгш байдлыг бодитоор хэрэгжүүлэхэд саад болж байна (ConnellW.R., 2002); (LeathwoodC.,, 2009). Түүнчлэн Монгол Улсын дээд боловсролын салбарт эмэгтэй суралцагчид 60 орчим хувийг, эрэгтэйчүүд 40 орчим хувийг эзэлж буй урвуу жендэрийн зөрүү нь дунд сургуулийн шатнаас хөвгүүдийг дэмжих бодлого дутагдсаны шууд үр дагавар юм (Хүрээлэн., 2024). Мөн алслагдсан бүс нутагт сургууль завсардаж буй хүүхдүүдийн 70–80 хувийг хөвгүүд эзэлж байгаа бөгөөд тэдэнд чиглэсэн уян хатан хөтөлбөр, санхүүгийн дэмжлэг дутагдаж байна (Бат-Эрдэнэ, 2023).

Тиймээс энэхүү судалгааны зорилго нь жендэрийн тэгш байдал хэмээх ойлголт их, дээд сургуулийн түвшинд ямар байгаа мөн түүнд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг оюутнуудын үзэл хандлагын хүрээнд шинжлэхэд оршино. Энэхүү судалгааны үр дүнгээр боловсролын бодлого боловсруулагчид, дээд боловсролын байгууллагууд нь жендэрт суурилсан ялгаатай хэрэгцээг ойлгох, шийдвэр гаргах үйл явцыг сайжруулахад хувь нэмэр оруулахаар зорьсон (UNESCO, 2019).

Судлагдсан байдал

Жендэрийн тэгш байдлын асуудал нь боловсролын хүртээмж, чанар, оролцооны үндэс суурь хэмээн тодорхойлогддог (Unterhalter, E., 2017). Жендэрийн тэгш байдал нь зөвхөн тоон харьцаанд бус, боловсролын үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, шийдвэр гаргах боломж, нийгэм-соёлын орчинд илэрч буй ялгаатай байдалтай нарийн холбоотой (StromquistN., 2006). Мөн (UNESCO, 2019)-ийн тайланд тэмдэглэснээр боловсрол дахь жендэрийн тэгш байдал нь сургуулийн орчин, багшийн хандлага, сургалтын агуулга болон нийгмийн хэвшмэл ойлголтоос шалтгаалан гүнзгийрэх хандлагатай байна. Энэ нь жендэрийн хэм хэмжээ хэмээх ойлголттой хамаатай юм. Учир нь тодорхой нийгэм, соёлын бүлэгт хамаарах эмэгтэй, эрэгтэй хүмүүст тухайлан тогтоосон стандарт, тэднээс хүлээх хүлээлтийг жендэрийн хэм хэмжээ гэдэг (Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, 2020). Түүнчлэн

хүний чадавх дээшилж, боломж бололцоо нэмэгдэхийн хэрээр сайн сайхан байдал улам бүр тэлж, харин эсрэгээр чадавх доройтож, боломж бүрдэхгүй бол хумигддаг. Иймд төрийн бүхий л бодлого, хөгжлийн стратегиуд нь эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн бүхий л хүрээнд хүмүүст адил тэгш боломжуудыг бүрдүүлэх, бий болгоход чиглэгдэх ёстой (А.Солонго, 2023).

Олон улс оронд их, дээд боловсролын хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоо харьцангуй нэмэгдсэн ч боловсролын агуулга, багшийн оролцоо, удирдлагын түвшинд шийдвэр гаргах эрх мэдэлд хүйсийн тэгш бус байдал хэвээр байна (MorleyL., 2010); (Leathwood, C., & Read, B., 2009). Судлаач (Skelton, C., 2012) их, дээд боловсролын хүрээнд жендэрийн тэгш байдал нь зөвхөн бодлогоор бус, байгууллагын соёл, сургалтын арга зүй, сэтгэлзүйн орчноос хамаардаг болохыг онцолжээ.

Оюутнуудын жендэрийн талаарх ойлголт нь тэдний гэр бүлийн орчин, сургалтын хөтөлбөр, багшийн хандлага, хамт олны уур амьсгал зэрэг олон хүчин зүйлээс хамаарч өөрчлөгддөг (FrancisB.,, 2005). Өмнөд Африкийн оюутнуудын дунд (BhanaD., 2009) хийсэн судалгаанд жендэрийн үүргийн хуваарилалт, хүлээлт нь эрэгтэй, эмэгтэй суралцагчдын оролцоо, аюулгүй байдалд тодорхой ялгаа үүсгэж байгааг тогтоосон. Мөн судлаач (ConnellW.R., 2002) боловсрол дахь "hegemonic masculinity" буюу давамгайлах эр хүйсийн соёл нь хүйсийн тэгш байдлыг сааруулж байгааг онцолжээ.

Харин Монгол Улсад боловсролын байгууллагын хүрээнд жендэрийн тэгш байдлын талаарх судалгаа хязгаарлагдмал боловч сүүлийн үед энэ талын судалгаа харьцангуй нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал: Судлаач (ЭрдэнэчимэгБ., 2020) боловсролын салбарт хүйсийн ялгаатай оролцоо, удирдлагын түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл багатай байдал, хэвшмэл ойлголтоос үүдэлтэй жендэрийн тэгш бус байдлыг онцолжээ. Түүнчлэн судлаач (ЭнхмааА., 2022) оюутнуудын медиа хэрэглээ болон жендэрийн хандлагыг шинжилсэн судалгаандаа нийгмийн мэдээллийн хэрэгслээр дамжин хэвшмэл ойлголт хэрхэн бэхэждэгийг харуулсан.

Эцэст нь дээд боловсролын хүрээнд жендэрийн тэгш байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг олон улсын судлаачид дараах үндсэн чиглэлүүдээр ангилжээ. Үүнд:

- Нийгэм-соёлын хүчин зүйлс (StromquistN., 2006); (Unterhalter, E., 2017)
- Сургалт-заах арга зүй, багшийн хандлага (MorleyL., 2010); (SkeltonC., 2012)
- (BhanaD., 2009); (FrancisB.,, 2005)
- Санхүү, эдийн засгийн хүртээмж (UNESCO, 2019)
- Төрийн бодлого, хууль эрх зүй (Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011)

Монголын нөхцөлд эдгээр хүчин зүйлс нь боловсролын салбарт хэрхэн илэрч буй, харилцан уялдааг нарийвчлан судалсан академик бүтээл цөөн байгаа нь энэхүү судалгааны ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна.

Арга зүй

Асуулгыг боловсруулахдаа үнэн зөв, найдвартай, харьцуулах боломжтой, хэрэгжихэд тохиромжтой байх чанарыг хангасан. Учир нь судалгааны агуулга нь эрэгтэй суралцагчдад чиглэсэн бодлого, дэмжлэгийн сул байдал, боловсролоос хөндийрөхөд нөлөөлөх гэр бүл, нийгэм, хувь хүний хүчин зүйлс болон жендэрийн үүрэг ба боловсролын үнэлэмжийн ялгаа гэсэн хүчин зүйлсээс бүрдсэн. Эдгээр хүчин зүйл тус бүрд 1–5 ликёрт үнэлгээ бүхий асуулгуудыг ашиглаж, өгөгдлийн найдвартай байдал (Cronbach’s Alpha), түүврийн хүрэлцээ, хүчин зүйлийн шинжилгээгээр асуулгын статистик шаардлагыг хангаж байгааг тогтоосон.

Иймд кластер, регрессийн нарийвчилсан шинжилгээг Jamovi программд гүйцэтгэж үр дүнг боловсрууллаа.

ОНОЛЫН АГУУЛГА

“Хүйс” (sex) гэдэг нь биологийн шинжээр тодорхойлогддог бол “жендэр” (gender) гэдэг нь нийгмийн бүтээл, соёлын хүлээлт, тогтсон хандлагын нийлбэр гэж үздэг. Жендэрийг (Butler, 1990) биологийн биш, харин “нийгмийн хувьд бүтээлч процесс” гэж тодорхойлсон бөгөөд “жендэр бол хийгддэг зүйл, төрдөг зүйл биш” хэмээн үздэг. Энэхүү хандлага нь боловсролын салбарын хүрээнд жендэрийн ойлголтыг хувь хүний өөрийгөө илэрхийлэх байдал, нийгмийн зүгээс тавигдах хүлээлттэй уялдуулан ойлгох боломжийг олгодог.

Боловсролын хүрээнд жендэрийн тэгш байдлыг (Fraser, 1997) зөвхөн оролцооны түвшинд бус, хуваарилалт (distribution) болон хүлээн зөвшөөрөл (recognition)-ийн аль алинд үндэслэх ёстой гэж үзсэн. Тэрээр шударга ёсны онолдоо боловсролын орчинд бүх хүйс тэгш хүлээн зөвшөөрөгдөж, боломжийн хувьд ялгаатай хэрэгцээтэй байж болох ч тэрхүү ялгаатай хэрэгцээг хангах замаар жинхэнэ тэгш байдлыг бүтээнэ гэжээ.

Түүнчлэн судлаач (Bhana, 2009) болон (Francis, 2005) нарын судалгаагаар сургалтын арга зүй, багшийн хандлага, суралцагч хоорондын харилцаа бүгд жендэрийн ойлголт, тэгш бус байдалд нөлөөлдөг гэжээ. Тэдний хувьд боловсролын агуулга нь зөвхөн мэдлэг дамжуулагч төдий бус, жендэрийн тухай ойлголтыг бүрдүүлэгч соёлын хэрэгсэл гэж үздэг. Харин боловсролын тогтолцоонд жендэрийн тэгш байдлыг хангахын тулд бодлого, хөтөлбөрөөс гадна сургалтын орчин, сэтгэлзүйн дэмжлэг, санхүүгийн хүртээмж, багшийн чадавх зэрэг олон талт хүчин зүйлсийг хослуулах хэрэгтэйг (UNESCO, 2019) онцолжээ.

Тиймээс энэхүү судалгаа нь “жендэрийн тэгш байдалд нөлөөлөх хүчин зүйлс”-ийн онолын үндэслэл болж өгнө.

Тоон судалгааны үр дүн

Судалгаанд нийт 423 оролцогч хамрагдсаны 51.3 хувь нь эрэгтэй, 48.7 хувь нь эмэгтэй байна. Насны хувьд дийлэнх буюу 84.2 хувь нь 18–25 насныхан байна. Оролцогчдын 67.4 хувь нь Улаанбаатар хотоос, 32.6 хувь нь орон нутгаас хамрагдсан. Боловсролын түвшний хувьд ихэнх нь бүрэн дунд (59.3 хувь) болон бакалаврын (29.3 хувь) боловсролтой байна. Ажил эрхлэлтийн хувьд 70.9 хувь нь оюутан. Түүнчлэн албан тушаалын хувьд 69.5 хувь нь оюутан байгаа нь судалгаанд залуу, суралцагчид давамгайлж оролцсоныг харуулж байна.

Хүснэгт 1. Давтамжын хүснэгт

Хүйс					
Эрэгтэй			Эмэгтэй		
217/ 51.3%			206/ 48.7%		
Нас					
18	18-25	26-33	34-40	41-47	48-54
5/ 1.2%	356/ 84.2%	21/ 5.0%	24/ 5.7%	6/ 1.4%	11/ 2.6%
Харьяалал					
Орон нутаг			Улаанбаатàр		
138. 32.6%			285/ 67.4%		
Боловсрол					
Доктор	Магистр	Баклавар	Тусгай дунд	Бүрэн дунд	Бүрэн бус дунд
2/ 0.5%	5/ 1.2%	124/ 29.3%	13/ 3.1%	251/ 59.3%	28%/ 6.6%
Ажил эрхлэлтийн байдал					

Оюутан	Хувийн байгууллага	Төрийн байгууллага	Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	Тэтгэвэрт	Бусад
300/ 70.9%	13.7%	24/ 5.7%	25/ 5.9%	1/ 0.2%	15/ 3.5%
Албан тушаал					
Ажилтан, албан хаагч		Оюутан	Дунд шатны удирдлага	Дээд шатны удирдлага	
22.9%		294/ 69.5%	23/ 5.4%	9/ 2.1%	

Түүврийн хүрэлцээтэй байдлын шинжилгээ

Судалгааг 423 түүвэртэйгээр эхлүүлсэн бөгөөд KMO болон Бартлеттын тестээр түүвэр эх олонлогийг төлөөлж чадаж байгаа эсэхийг шалгаж үзэв. Түүврийн хүрэлцээтэй байдлын тестээр KMO коэффициент нь 0.941 дундажтай гарсан нь ≥ 0.6 хязгаарыг хангалттай давж байгаа нь түүврийн хүрэлцээтэй байдал өндөр байгааг харуулж байна. Харин Бартлеттын тестийн хувьд, Хи-квадрат статистик нь 7688 ($df=406$, $p < .001$) байгаа нь хувьсагчдын хоорондын хамаарал өндөр байгааг харуулж байна.

Хүснэгт 2. KMO болон Бартлеттын тест

KMO and Bartlett's Test		
Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.		.941
Bartlett's Test of Sphericity	Approx. Chi-Square	7688
	df	406
	Sig.	<.001

Эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь өгөгдөл хүчин зүйлсийн шинжилгээнд тохиромжтой болохыг баталж, түүврийн хүрэлцээтэй байдал өндөр төдийгүй хүчин зүйлс хоорондын хамаарал хүчтэй байгааг харуулж байна.

Хүснэгт 3. Бартлеттын тест

Хүснэгт 4. *KMO дэлгэрэнгүй хүснэгт*

	Bartlett's Test of Sphericity		
	χ^2	df	p-value
	7688	406	<.001
KMO Measure of Sampling Adequacy			
		MSA	
Overall		0.941	

Найдвартай байдлын шинжилгээ

Хүснэгт 5. Кронбахын альфа

Scale Reliability Statistics	
	Cronbach's α
scale	0.949


Найдвартай байдлын шинжилгээгээр Кронбахын альфа 0.949 гарсан нь түүвэр эх олонлогийг маш сайн төлөөлөх чадвартай бөгөөд түүвэр хангалттай гэж үзэв.

Хүчин зүйлсийн шинжилгээ

Хүчин зүйлсийн фактор шинжилгээний үр дүнд Scree Plot графикийн Eigenvalue-г 1 хязгаараар авч үзэхэд хувьсагчууд гурван хүчин зүйлд жигд хуваарилагдах боломжтой байв. ('Principal axis factoring' арга болон 'oblimin' эргүүлэг хийсэн)

Хувьсагчдыг гурван хүчин зүйлсэд 0.4 хязгаараар нэгтгэн, утга бүхий нэрээр илэрхийлэв. Мэдээж 0.4 хязгаараас бага хувьсагчуудыг хассан.

Зураг 1. *Scree Plot график*



Хүчин зүйлс тус бүрийн найдвартай байдлын шинжилгээ

Хүчин зүйлс тус бүрд хуваарилагдах хувьсагчдыг нэгтгэн Кронбахын альфаг шалгахад бүгд > 0.8 хязгаараас их буюу энэхүү шинжилгээнд сайн нөлөөлөлтэй гарсан тул хүлээн зөвшөөрөв.

Хүснэгт 6. Гурван хувьсагчдын кронбахын альфа

№	Хүчин зүйлс	Хувьсагчийн тоо	Кронбахын альфа
1	Эрэгтэй суралцагчдад чиглэсэн бодлого, дэмжлэгийн сул байдал	11	0.918
2	Боловсролоос хөндийрөхөд нөлөөлөх гэр бүл, нийгэм, хувь хүний хүчин зүйлс	8	0.886
3	Жендэрийн үүрэг ба боловсролын үнэлэмжийн ялгаа	7	0.848
	Нийт хувьсагчид	**26**	**0.949**

Хүснэгт 7. Найдвартай байдлын шинжилгээ, хүчин зүйлсийн CR, AVE үзүүлэлтүүд

№	Хүчин зүйлс	CR	AVE
1	Эрэгтэй суралцагчдад чиглэсэн бодлого, дэмжлэгийн сул байдал	0.919	0.512
2	Боловсролоос хөндийрөхөд нөлөөлөх гэр бүл, нийгэм, хувь хүний хүчин зүйлс	0.887	0.495
3	Жендэрийн үүрэг ба боловсролын үнэлэмжийн ялгаа	0.853	0.454

Найдвартай байдлын Composite Reliability(CR) болон Average Variance Extracted (AVE) үзүүлэлтүүдийг тооцоолов. Үүнд хүчин зүйлс бүрийн CR үзүүлэлт өндөр гарсан нь хүчин зүйлсийн найдвартай байдал болоод хүчин төгөлдөр байдлыг хангаж байгааг илтгэж байгаа юм. Харин AVE үзүүлэлт нь 0.45-0.51 хооронд хэлбэлзэж байгаа нь сул ч гэсэн CR үзүүлэлт өндөр гарсан тул хүчин төгөлдөр хэмээн тооцов.

Регрессийн шинжилгээ

Регрессийн шинжилгээг хүчин зүйлс тус бүрд бүх сул хувьсагчтай холбогдуулан шинжилж, гарсан үр дүнгийн хамгийн хүчтэй нөлөө бүхий таван хувьсагчийг авч үзэв.

Хүснэгт 8. Регрессийн шинжилгээ

Хүчин зүйлс	p	Stand. Estimate
Эрэгтэй суралцагчдад чиглэсэн бодлого, дэмжлэгийн сул байдал		
1. Эрэгтэй суралцагчдыг дэмжсэн бодлого дутмаг байна	<.001	0.1755
1. Эрэгтэйчүүдийн боловсролыг дэмжихэд төрийн анхаарал сул байгаа	<.001	0.1104
1. Сошиал медиа болон олон нийт дэх дүр төрх нь эрэгтэйчүүдийн боловсролд нөлөөлж байна	<.001	0.1140
1. Нийгмийн зүгээс эрэгтэй суралцагчид бага үнэлэгддэг гэж би боддог.	<.001	0.1997
1. Сургуулийн орчинд эрэгтэй суралцагчдын хэрэгцээ хангалтгүй анхаарагддаг	<.001	0.1278
Боловсролоос хөндийрөхөд нөлөөлөх гэр бүл, нийгэм, хувь хүний хүчин зүйлс		
2. Манай гэр бүлд эрэгтэй хүүхдийг сургуулиа дүүргэх шаардлага бага гэж үздэг.	<.001	0.1214

2. Найз нөхөд маань суралцаж байгаа эрэгтэйг “эмэгтэйлэг” гэж шоолдог байсан	<.001	0.1874
2. Манай гэр бүл миний боловсролд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд хүндрэлтэй байсан	<.001	0.1471
2. Би боловсролоос илүү эрт хөдөлмөр эрхлэхийг сонгосон.	<.001	0.2328
2. Миний дотоод урам зориг байнга сул байсаар ирсэн.	<.001	0.1197
Жендэрийн үүрэг ба боловсролын үнэлэмжийн ялгаа		
3. Эрэгтэй хүн бодит амьдрал дээр ажиллаж байж туршлага хуримтлуулдаг.	<.001	0.2396
3. Эрэгтэй хүнийг “эр хүн шиг” байлгахын тулд боловсролоос илүү сахилга, хатуу хүмүүжил чухал	<.001	0.2191
3. Эмэгтэйчүүд дээд боловсрол эзэмших нь илүү зохимжтой	<.001	0.2667
3. Дээд боловсрол эрэгтэй хүний хувьд ажил олох гол шалгуур биш.	<.001	0.1484
3. Мэргэжлийн сургалт, гар урлалын чиглэл нь эрэгтэйчүүдэд илүү тохиромжтой	<.001	0.1376

Дээрх судалгааны үр дүнгээр хэмжилтүүд найдвартай бөгөөд хүчин төгөлдөр гарсан нь жендэрийн тэгш байдлын хэмжүүрүүд хоорондоо статистик ач холбогдолтой байгааг баталсан. Үүний үр дүнд эрэгтэй суралцагчдад чиглэсэн бодлого, дэмжлэгийн сул байдал, боловсролоос хөндийрөхөд нөлөөлөх гэр бүл, нийгэм, хувь хүний хүчин зүйлс, жендэрийн үүрэг ба боловсролын үнэлэмжийн ялгаа нь “жендэрийн тэгш байдал хэмээх ойлголтод нөлөөлөх” бөгөөд таамаглалаа батлах хүчин зүйлс мөн хэмээн тогтоолоо.

H1: Эрэгтэй суралцагчдад чиглэсэн бодлого, дэмжлэгийн сул байдал нь жендэрийн тэгш байдалд нөлөөлнө.

H2: Боловсролоос хөндийрөхөд нөлөөлөх гэр бүл, нийгэм, хувь хүний хүчин зүйлс нь жендэрийн талаар зөрүүтэй хандлагад нөлөөлнө.


H3: Жендэрийн үүрэг ба боловсролын үнэлэмжийн ялгаа нь зөрүүтэй байдалд нөлөөлнө.

Судалгаагаар таамаглал батлагдсан бөгөөд регрессийн шинжилгээний үр дүнд эрэгтэй суралцагчдад үзүүлэх дэмжлэг бага буюу тэдэнд чиглэсэн бодлого, дэмжлэгийн сул байдал, олон нийтийн хэвшмэл ойлголтоос үүдэж жендэрийн тэгш байдлын ойлголт алдагдаж буй нь батлагдсан. UNESCO мөн боловсролын бодлого нь “gender-responsive” буюу жендэрт мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэхгүй тохиолдолд суралцагчдын жендэрийн тэгш бус байдал гүнзгийрдэг гэж үзжээ. (UNESCO, 2019). Түүнчлэн (Connell R. , 2005). -ийн судалгаагаар “эршүүд чанарын хэвшмэл ойлголт” нь хөвгүүдийг боловсролоос хөндийрөхөд хүргэдэг болохыг онцолжээ. Харин эрэгтэй суралцагчид боловсролоос хөндийрөхөд нөлөөлөх гэр бүл, нийгэм, хувь хүний хүчин зүйлийн регрессийн шинжилгээний үр дүнд санхүүгийн байдал, гэр бүл, найз нөхөд болоод эрт хөдөлмөр эрхлэлтээс шалтгаалан дээд боловсрол эзэмших үгүй нь шийдэгдэж байгаа нь ажиглагдаж байна. Үүнийг судлаач Pierre Bourdieu-ийн “соёлын капитал”-ын онол нь гэр бүлийн нөлөө боловсролын амжилтад шууд нөлөөлдөг болохыг харуулжээ (Bourdieu, P., 1986). Харин Жендэрийн үүрэг ба боловсролын үнэлэмжийн ялгаа хүчин зүйл дээр эмэгтэйчүүдэд дээд боловсрол зохимжтой, эрэгтэйчүүдэд боловсрол нь ажил олох гол шалгуур биш гэх хуучинсаг үзэл ихээр нөлөөлж байгаа нь тодорхой байна. Судалгаагаар боловсролыг “эмэгтэйчүүдэд илүү тохиромжтой” гэж үзэх хэвшмэл ойлголт нь хөвгүүдийн сурах идэвхийг бууруулдгаар тайлбарлаж болох юм (Legewie, 2012). Үүний үр дүнд эцэг эхчүүд болон асран хамгаалагчид охидын боловсролд анхаарч, эрэгтэйчүүдийг мэргэжлийн сургалт, гар урлалын чиглэлд сургаж эрт ажилд гаргах үзэгдэл их нөлөөлөлтэй байна.

Кластер шинжилгээ

Хүчин зүйлсийг кластер шинжилгээгээр шалгав. Үүнд гурван хүчин зүйлтэй тул гурван бүлэгт хуваана гэж тооцоолон Hierarchical Clustering[1] арга ашиглан Dendogram-с гурван кластераа тодорхойлов.

Зураг 2. *Dendogram бүлэглэсэн байдал*



Түүнчлэн кластер хоорондын зайг тодорхойлж a, b, c-ээр дүрслэв. Энэ нь кластер буюу гурван бүлэгт хуваасан загвар юм. Мэдээж дөрвөн бүлэгт хуваавал илүү тэгш хуваарилагдах шинжтэй байгаа ч энэхүү судалгааны гурван хүчин зүйлсэд “гурван бүлэг кластер” байх нь хангалттай тул ийнхүү хуваарилав.

Дээрх гурван бүлэг кластераа шалган K-means Clustering ашиглан хүчин зүйлс болон кластерууд хоорондын харилцааг тодорхойлж тохирох нэрийг зохион олгов (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Кластеруудын төвлөрсөн байдлын хүснэгт

Кластер	Хүчин зүйлс		
	1	2	3
1. Жендэрийн хуучинсаг буюу "уламжлалт" үзэлтэй бүлэг	-1.194	-0.74	-1.042
2. Шилжилтийн буюу "төвийг сахисан" үзэлтэй бүлэг	0.164	-0.082	0.19
3. Жендэрийн тэгш байдлыг дэмжих хандлагатай бүлэг	1.292	1.5	0.953

Үүнд жендэрийн хуучинсаг буюу "уламжлалт" үзэлтэй бүлэг кластер нь бүх хүчин зүйлд -1 хязгаарт илүү ойртож байгаа нь дээд боловсролд үзэгдэх жендэрийн зөрүүтэй байдал нь энгийн үзэгдэл гэх үзэлтэй бүлэг гэж үзээд ‘жендэрийн хуучинсаг’ буюу "уламжлалт" үзэлтэй бүлэг хэмээн нэрлэв. Харин Шилжилтийн буюу "төвийг сахисан" үзэлтэй бүлэг кластер нь дундаж буюу 0 хязгаартай ойр байгаа нь тодорхой байр суурьгүй эсвэл нийгмийн өөрчлөлтийн шилжилтийн шатанд байгаа бүлэг хэмээн үзэж ‘шилжилтийн’ буюу "төвийг сахисан" үзэлтэй бүлэг хэмээн нэрлэв. Жендэрийн тэгш байдлыг дэмжих хандлагатай бүлэг кластер нь 1 хязгаар хангалттай давсан (хүснэгт 9, 1, 2-р хүчин зүйлд) бөгөөд үүнийг боловсрол, түүний үнэ цэнэ болоод “жендэрийн тэгш эрхийг хүчтэй дэмжиж буй” бүлэг гээд ‘жендэрийн тэгш байдлыг дэмжих хандлагатай бүлэг’ хэмээн нэрлэв.

Ийнхүү бэлэн болсон кластер дээр жендэрийн тэгш байдалд хүйс, нас, боловсрол гурав хэрхэн хамаарч байгааг авч үзэхэд:

Дээд боловсролын хүрээнд “жендэрийн тэгш байдал хэмээх ойлголт” нь бодитой оршин байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан эрэгтэй, эмэгтэй оролцогчид энэ талаар өөр өөр үзэл бодолтой байгааг харж болно. Харин шилжилтийн буюу "төвийг сахисан" үзэлтэй бүлэг эрэгтэй, эмэгтэй оролцогчдын хувьд ердөө 5-аар зөрүүтэй буюу нийт судалгаанд хамрагдагсдын 60 гаруй хувийг эзэлж байна. Энэхүү үр дүн нь (Inglehart, R., & Norris, P. , 2003)-ийн “үнэт зүйлийн өөрчлөлтийн онол”-оор залуу үе уламжлалт үнэт зүйлсээс либерал, тэгш эрхийн чиглэлд шилждэг болохыг илтгэжээ. Түүнчлэн (Survey., 2022)-ийн өгөгдлөөр залуус ахмад үеэс илүү жендэрийн тэгш байдлыг дэмжих боловч зарим нь

[1] Өгөгдлийг урьдчилан бүлгийн тоо заахгүйгээр шат дараалан *нэгтгэх эсвэл задлах* замаар ангилдаг кластер шинжилгээний арга

“саармаг/шилжилтийн” байр суурьтай хэвээр байдаг хэмээх үр дүнтэй нийцсэн. Үүнээс харахад олон нийтийг сургалт, семинар зэрэгт хамруулах байдлаар жендэрийн талаарх шилжилтийн хандлагыг хамгийн бага хувийг эзэлж буй “тэгш байдлыг дэмжих хандлага”-тай болгож нэмэгдүүлж болохоор байна.

Хүснэгт 10. Кластерт хүйсийг хуваарьлав

Кластер	Хүйс		Нийт
	Эмэгтэй	Эрэгтэй	
1. Жендэрийн тэгш байдлыг дэмжих хандлагатай бүлэг	18	48	66
2. Шилжилтийн буюу "төвийг сахисан" үзэлтэй бүлэг	128	123	251
3. Жендэрийн хуучинсаг буюу "уламжлалт" үзэлтэй бүлэг	60	46	106
Нийт	206	217	423

Хүснэгт 11. Хи-квадрат тест

	Value	df	p
χ^2	15.3	2	<.001
N	423		

Үүнд жендэрийн тэгш байдлын Хи-квадрат тестийн (Хүснэгт 14) үр дүнд $p < .001$ гарсан нь жендэрийн тэгш байдал болон кластер бүлгүүд хоорондоо статистик ач холбогдолтой байгааг батлав. Мөн One-Way ANOVA тестийн (Хүснэгт 12) үр дүнд бүх хүчин зүйлсийн $p < .001$ гарсан нь кластерууд онолын үндэслэлтэйг баталж байна.

Хүснэгт 12. One-Way ANOVA

Хүчин зүйлс	F	df1	df2	p
1. Жендэрийн тэгш байдлыг дэмжих хандлагатай бүлэг	342	2	150	<.001
2. Шилжилтийн буюу "төвийг сахисан" үзэлтэй бүлэг	196	2	159	<.001
3. Жендэрийн хуучинсаг буюу "уламжлалт" үзэлтэй бүлэг	164	2	157	<.001

Кластерт үзүүлэх нас болон боловсролын ялгаатай байдлыг авч үзэхэд дараах байдалтай гарав. Үүнд насны Хи-квадрат тестийн үр дүн (Хүснэгт 13) $p = .152$ гарсан нь $p < .05$ хязгаарыг хангасан тул насны нөлөө байна хэмээн дүгнэв. Мөн боловсролын Хи-квадрат тестийн үр дүн (Хүснэгт 14) $p = .152$ гарсан нь мөн хязгаарыг хангаж байгаа тул оролцогчдын боловсролын түвшин, нас нь “жендэрийн тэгш байдал” хэмээх ойлголтод чухал нөлөө үзүүлж байна. Учир нь шилжилтийн буюу “төвийг сахисан” үзэлтэй бүлэгт дийлэнх буюу 217 нь 18-25 насны залуу оролцогчид байна. Дараагаар нь жендэрийн тэгш байдлыг дэмжих хандлагатай оролцогчид мөн эдгээр залуус оржээ. Энэхүү үр дүн нь (UNESCO, 2020) залуучууд нь жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх “гол хөдөлгөгч хүч” гэж тодорхойлсонтой нийцэж байна. Мөн (OCED, 2017)-ийн судалгаагаар боловсролтой, залуу хүмүүс жендэрийн тэгш байдлыг илүү дэмждэг болохыг дээрх судалгааны үр дүн баталж байна.

Хүснэгт 13. Кластерт насыг хуваарьлав

Нас:							
Кластер	<18	18-25	26-33	34-40	41-47	48-54	Нийт
3	1	57	4	3	0	1	66
2	3	217	7	16	4	4	251
1	1	82	10	5	2	6	106
Нийт	5	356	21	24	6	11	423

Хүснэгт 14. *Хи-квадрат*

	Value	df	p
χ^2	14.5	10	0.152
N	423		

Хүснэгт 15-д бүрэн дунд боловсролтой, бакалаврын зэрэг

горилж буй залуу хүмүүс нийт 231 буюу олонх байгаа нь шилжилтийн буюу “төвийг сахих” үзэлтэй болохыг илтгэж байна. Энэхүү үр дүн нь судлаач (Bourdieu, P., 1984)-ийн онолоор боловсрол нь үнэт зүйл, хандлагыг “дахин бүтээх” орон зай бөгөөд суралцагчид шинэ ба хуучин үнэт зүйлсийн дунд байдаг гэдэгтэй нийцсэн. Түүнчлэн энэ бүлгийн 91 оролцогч мөн жендэрийн тэгш байдлыг дэмжих хандлагатай байгаа нь олон нийтийн ойлголтыг өөрчлөх бүрэн боломжтойг харуулж байна. Учир нь (ArnotM., 2002) судалгаандаа их, дээд сургуулийн оюутнуудын дунд “mixed” буюу төвийг сахисан хандлага түгээмэл байдаг нь нийгмийн нормыг шүүмжлэн авч үзэх үйл явцтай холбоотой болохыг онцолжээ.

Хүснэгт 15. Кластерт боловсролыг тусгав

	Боловсрол:						
Кластер	Доктор	Магистр	Баклавар	Тусгай дунд	Бүрэн дунд	Бүрэн бус дунд	Нийт
3	1	0	18	5	38	4	66
2	1	2	73	2	158	15	251
1	0	3	33	6	55	9	106
Нийт	2	5	124	13	251	28	423

Энэ нь (Women, 2018)-д олон нийтийн ойлголтыг өөрчлөхөд залуус хамгийн мэдрэмтгий, нөлөөлөгч бүлэг гэж онцолдог болохыг илтгэж байна. Харин уламжлалт болоод тэгш эрхийг дэмжих хандлагатай бүлэг кластеруудад илүү ач холбогдол өгч ажиллах нь зүйтэй байна. Учир нь (UNICEF, 2020)-ийн тайланд залуус зөв мэдээлэл, боловсролын нөлөөгөөр богино хугацаанд жендэрийн тэгш байдлыг дэмжих хандлагад шилждэг гэж үзсэн.

Хүснэгт 16. Хи-квадрат

Value		df	p
χ^2	19	10	0.04
N	423		

Энэхүү шинжилгээний үр дүнд гурван кластер илэрсэн бөгөөд жедэрийн тэгш байдлын талаарх ойлголт ерөнхийдөө жигд байна. Үүнээс дээд боловсролын хүрээнд тулгамдах “жендэрийн тэгш байдал” хэмээх ойлголтын хувьд шилжилтийн болоод тодорхой байр суургүй оролцогчид дийлэнх хувийг эзэлж байв.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнд үндэслэн дараах шийдлүүдийг дэвшүүлж байна. Үүнд: Боловсролын бодлогод эрэгтэй суралцагчдын онцлог хэрэгцээг тусгасан зорилтот хөтөлбөр, дэмжлэгийн механизм бий болгох шаардлагатай. Сургалтын арга зүйг жендэрийн мэдрэмжтэй болгон шинэчилж, эрэгтэй суралцагчдад тохирсон идэвхтэй, практик сургалтын арга барил нэвтрүүлэх. Түүнчлэн эдийн засгийн шалтгаанаар сургууль завсардах эрсдэлтэй болон амьжиргааны түвшин доогуур эрэгтэй суралцагчдад зориулсан тусгайлсан тэтгэлэг, урамшууллын квотыг их, дээд сургууль болон орон нутгийн төсөвт суулгах. Сэтгэлзүйн болон зөвлөгөө өгөх үйлчилгээг сайжруулж, эрэгтэй суралцагчдын урам зориг, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх.

Жендэрийн тэгш байдлын талаарх их, дээд сургуулийн оюутан суралцагчдын ойлголт хэр байгааг энэхүү судагаагаар тодруулахыг зорьсон. Уг судалгаа нь эрэгтэй суралцагчдад чиглэсэн бодлого, дэмжлэгийн сул байдал, Боловсролоос хөндийрөхөд нөлөөлөх гэр бүл, нийгэм, хувь хүний хүчин зүйлс, Жендэрийн үүрэг ба боловсролын үнэлэмжийн ялгаа гэсэн хүчин зүйлсийн хүрээнд тоон судалгааны үр дүнг боловсруулан регресс болон кластер зэрэг нарийвчилсан шинжилгээнүүдийг хийж дэвшүүлсэн “3 таамаглал”-ыг батлав. Энэхүү судалгаанаас дараах гол үр дүнгүүд гарсан болно. Үүнд: Хүчин зүйлсийн шинжилгээгээр эрэгтэй суралцагчдад чиглэсэн бодлого, дэмжлэгийн сул байдал, боловсролоос хөндийрөхөд

нөлөөлөх гэр бүл, нийгэм, хувь хүний хүчин зүйлс болон жендэрийн үүрэг ба боловсролын үнэлэмжийн ялгаа гэсэн “3 үндсэн хүчин зүйлс”-ийг тодорхойлсон. Жендэрийн тэгш байдалд эдгээр хүчин зүйлс хүчтэй нөлөөлж байгааг тогтоов. Учир нь жендэрт мэдрэмжтэй бодлогын хэрэгжилт хангалтгүйгүйгээс үүдэлтэй жендэрийн тэгш бус байдал гүнзгийрэх төдийгүй эрэгтэйлэг чанарын хэвшмэл ойлголтоос үүдэн хөвгүүд боловсролоос хөндийрөхөд хүргэдэг шалтгааныг анхаарах шаардлагатайг илтгэж байна. Түүнчлэн регрессийн шинжилгээгээр жендэрийн хэвшмэл ойлголт хамгийн хүчтэй нөлөө бүхий хүчин зүйлс болох нь тогтоогдсон. Мөн кластер шинжилгээний үр дүнд гурван кластер илэрсэн бөгөөд гол зүйл болох жендэрийн тэгш байдлын ойлголт ерөнхийдөө жигд байна. Гэвч уламжлалт болоод тэгш эрхийг дэмжих хандлагатай бүлэг кластеруудад илүү ач холбогдол өгч ажиллах нь зүйтэй байна.

Уг судалгааны ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд: Жендэрийн тэгш байдлын асуудлыг боловсролын салбарт шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлов. Бодлого боловсруулагчид болон боловсролын байгууллагатай холбоотой шийдвэр гаргалтад ашиглах бодит өгөгдөл, нотолгоо болохоор байна. Эрэгтэй суралцагчдын боловсролын хүрээний оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр боловсруулах суурь судалгаа болж өгнө. Мөн нийгэмд тогтсон хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн онол, практикийн ач холбогдолтой.

Кластер шинжилгээгээр илэрсэн "уламжлалт хандлагатай" болон "тэгш эрхийг дэмждэг" бүлгүүдийн онцлогт тохируулан олон нийтийн ухамсарт нөлөөлөх соёл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах. Энэхүү тоон судалгааны регресс, кластер шинжилгээний үр дүнг улам гүнзгийрүүлж, сургуулиас хөндийрсөн эрэгтэй суралцагчид болон тэдний гэр бүлээс чанарын судалгааны аргаар (фокус бүлгийн ярилцлага, кэйс судалгаа) нарийвчилсан шалтгааныг тодруулах. Боловсролын салбарт жендэрийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлж эхэлсний дараа эрэгтэй суралцагчдын сурлагын амжилт болон боловсрол эзэмших байдал зэрэгт гарах өөрчлөлтийг хянах лонгитуд буюу урт хугацааны ажиглалтын судалгааны суурийг тавих боломжтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Arnot, M. (2002). *Reproducing gender? Essays on educational theory and feminist politics.* London: RoutledgeFalmer.
2. Bhana, D. (2009). “Being boys”: Understanding learner resistance in schoolboy identities in South Africa. *Educational Review, 61(2),* 165–175.
3. Bourdieu, P. (1984). *Distinction: A social critique of the judgement of taste.* Cambridge: MA: Harvard University Press.
4. Bourdieu, P. (1986). *The forms of capital. In J. Richardson (Ed.), Handbook of theory and research for the sociology of education (pp. 241–258).* New York: Greenwood.
5. Butler, J. (1990). *Gender Trouble: Feminism and the Subversion of Identity.* Routledge.
6. Connell, R. (2005). *Masculinities (2nd ed.).* Berkeley: University of California Press.
7. Connell, R. W. (2002). *Gender. Polity Press.* Cambridge (UK) and Malden, MA (USA): Polity Press (co-published with Blackwell Publishers in the UK and US).
8. Francis, B. &. (2005). *Reassessing gender and achievement: Questioning contemporary key debates. Routledge.* London, United Kingdom (also co-published in New York, USA): Routledge.
9. Fraser, N. (1997). *Justice Interruptus: Critical Reflections on the “Postsocialist” Condition.* Routledge.
10. Hutchinson, L. U., & editor, S. I. (2017). *The global status of women and girls: A multidimensional perspective.* New York, NY, United States: Lexington Books.
11. Inglehart, R., & Norris, P. (2003). *Rising tide: Gender equality and cultural change around the world.* Cambridge: Cambridge University Press.
12. Leathwood, C. &. (2009). *Gender and the Changing Face of Higher Education: A Feminized Future? Palgrave Macmillan.* Maidenhead, Berkshire, England; also printed in New York, NY, USA: Society for Research into Higher Education / Open University Press (McGraw-Hill UK distribution).
13. Leathwood, C., & Read, B. (2009). *Gender and the changing face of higher education: A feminized future?* Basingstoke, Hampshire, United Kingdom: Palgrave Macmillan.
14. Legewie, J. &. (2012). School context and the gender gap in educational achievement. *American Sociological Review,* 77(3), 463–485.
15. Morley, L. (2010). Gender mainstreaming: Myths and measurement in higher education in Ghana and Tanzania. *Compare, 40(4),* 533–550.
16. Morley, L. (2014). Lost leaders: Women in the global academy. *Higher Education Research & Development, 33(1),* 114–128.
17. OECD. (2017). *Education at a glance 2017: OECD indicators.* Paris: OECD Publishing.
18. Skelton, C. (2012). Men teachers and the “feminised” primary school: A review of the literature. *Educational Review, 64(1),* 1–20.
19. Stromquist, N. P. (2006). Gender, education, and the possibility of transformative knowledge. *Compare, 36(2),* 145–161.
20. Survey, W. V. (2022). WVS Wave 7 (2017–2022) findings. : Retrieved from https://www.worldvaluessurvey.org-ээс Гаргасан
21. UN, Women. (2018). *Gender Equality in Academia and Research.* Paris: GEAT Tool.
22. UNESCO. (2015). *A Guide for Gender Equality in Teacher Education Policy and Practices.* Paris: UNESCO Publishing.
23. UNESCO. (2019). *Global Education Monitoring Report 2019: Gender report—Building bridges for gender equality.* Paris, France (UNESCO headquarters): UNESCO.
24. UNESCO. (2019). *Global Education Monitoring Report 2019: Gender report—Building bridges for gender equality.* Paris, France: UNESCO.
25. UNESCO. (2019). *Global education monitoring report: Gender report.* Paris: UNESCO.
26. UNESCO. (2020). *Global Education Monitoring Report 2020: Inclusion and Education – All Means All.* Paris: UNESCO Publishing.

27. UNESCO. (2020). *Global education monitoring report: Inclusion and education.* Paris: UNESCO.
28. UNESCO. (огноо байхгүй). *Annual Report 2020–2021.* New York, USA: United Nations Entity for Gender Equality and the Empowerment of Women (UN Women).
29. UNICEF. (2020). *Gender equality: Global annual results report.* New York: UNICEF.
30. Unterhalter, E. (2005). Global inequality, capabilities, social justice: The Millennium Development Goal for gender equality in education. *International Journal of Educational Development, 25(2),* 111–122.
31. Unterhalter, E. (2015). *Measuring gender equality in education.* Paris: UNESCO.
32. Unterhalter, E. (2016). *Gender and Education in the Global Polity.* New York: Wiley: In Handbook of Global Education Policy.
33. Unterhalter, E. (2017). Gender and education in the global polity of the twenty-first century: Sustainable development goals and the education of girls? *Comparative Education, 53(2),* 119–132.
34. Women, U. (2018). *Turning promises into action: Gender equality in the 2030 Agenda.* New York: UN Women.
35. Энхмаа, А. (2022). Медиа хэрэглээ ба жендэрийн ойлголтын судалгаа. *Нийгмийн ухааны эрдэм шинжилгээний бичиг, 19(2),* , 92–104.
36. Эрдэнэчимэг, Б. (2020). Боловсрол дахь жендэрийн тэгш байдлын тулгамдсан асуудал. *Боловсрол Судлал, 10(1),* , 45–56.